

## АРХАНГАЙ АЙМГИЙН ТАРИАТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 09

Хорго

### ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 35.1.14 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн “Аргачлал батлах тухай” 192, А/234 дүгээр тушаалыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ээлжит долоодугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын хураамжийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Уг тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12-р сарын 17-ны өдрийн 11 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4. Хог хаягдлын хураамжийг тогтоосон хэмжээгээр айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас төсөвт төвлөрүүлэн, сумын хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгуулах, цуглуулах, тээвэрлэх, булшлах ажлыг зохион байгуулж, төсвийг зориулалтын дагуу зарцуулахыг сумын Засаг дарга (Н.Чинбат)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

О.ОТГОНБАЯР



*Тариат сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн  
09 дүгээр тогтоолын хавсралт*

**СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИН СУУЖ БУЙ АЙЛ ӨРХ,  
АЖ АХУЙН НЭГЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРУУД, АЛБАН  
БАЙГУУЛЛАГУУДААС ГАРЧ БАЙГАА АХУЙН БОЛОН ХУУРАЙ ХОГ  
ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

№	Хураамж төлөх хуулийн этгээд, иргэд	Сард авах хураамжийн хэмжээ (төгрөг)
01	ЗДТГ	10 000
02	ЕБС	22 000
03	Хүүхдийн цэцэрлэг	15 000
04	ЭМТ	12 000
05	Соёлын төв	10 000
06	Аж ахуйн нэгж, дэлгүүр (30 м <sup>2</sup> хүртэл)	15 000
	Аж ахуйн нэгж, дэлгүүр (30 м <sup>2</sup> –аас дээш)	20 000
07	Гуанз, цайны газар	10 000
08	Эмийн сан	10 000
09	Банк санхүүгийн байгууллага	13 000
10	Шатахуун түгээх станц	15 000
11	Аялал жуулчлал, амралтын газар	25 000
12	Гэр буудал, Зочид буудал	10 000
13	Үсчний газар	15 000
14	Авто засвар, дугуй засвар	20 000
15	Сумын төвийн айл өрх	4000
16	Уурын зуух	25 000
17	Гадаадын жуулчин (1 удаа нэвтрэх)	2 500
18	Дотоодын амрагч (1 удаа нэвтрэх )	1 000
19	Хөдөөгийн багийн айл өрх (жилд)	8 000
20	Сумын төвд байгаа малтай өрх (сард 1 бод)	6 000
	Сумын төвд байгаа малтай өрх (сард 1 бог)	1 000
21	Ус цаг уурын Тариат өртөө	10 000
22	Эрэн хайх аврах бүлэг	10 000
23	Мал эмнэлэг	10 000
24	Шуудан холбооны салбар	10 000
25	Цагдаагийн тасаг	10 000

## **ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ**

2026 оны 4 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар А/80

Улаанбаатар  
хот

### **ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зэргийн нэмэгдэл олгох журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газар /В.Рэнцэнханд/, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны жил бүрийн төсөвт тусгаж, хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар /Б.Батжаргал/-т тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/137 дугаар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/29 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэхүү тушаалыг 2026 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

САЙД

Т.АУБАКИР

*Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн А/80 дугаар тушаалын хавсралт*

## **НИЙГМИЙН ДААТГАЛЫН УЛСЫН БАЙЦААГЧИД МЭРГЭШЛИЙН ЗЭРГИЙГ ТОГТООХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэргийг тогтоох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зэргийн нэмэгдэл олгох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Нийгмийн даатгалын улсын байцаагч нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт заасан мэргэшлийн зэрэгтэй байна.

1.3.Мэргэшлийн зэрэг нь нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг /цаашид “нийгмийн даатгалын байгууллага” гэх/-т ажиллаж байгаа улсын ахлах байцаагч болон улсын байцаагчийн эрхтэй байцаагч /цаашид “улсын байцаагч” гэх/-д хамаарна.

1.4.Итгэмжит зөвлөх мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 30 хувийн, зөвлөх мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 20 хувийн, тэргүүлэх мэргэшлийн зэрэг авсан улсын байцаагчид 15 хувийн нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингаас тооцож сар бүр олгоно. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанытөсөвт жил бүр тусгаж батлуулна.

1.5.Итгэмжит зөвлөх, зөвлөх, тэргүүлэх мэргэшлийн зэргийг Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэгт заасны дагуу хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгож, хүчингүй болгох, түдгэлзүүлнэ.

### **Хоёр.Мэргэшлийн зэрэг олгох шалгуур үзүүлэлт**

2.1.Тэргүүлэх мэргэшлийн зэргийг улсын байцаагчийн шалгалтад 2 ба түүнээс дээш удаа тэнцсэн доор дурдсан шалгуур хангасан улсын байцаагчид олгоно. Үүнд:

2.1.1.нийгмийн даатгалын байгууллагад 6-аас доошгүй жил ажилласан байх;

2.1.2.төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр сүүлийн 1 жилийн хугацаанд “Маш сайн”, “Хэвийн” үнэлгээтэй дүгнэгдсэн байх;

2.1.3.сүүлийн 1 жил ёс зүйн хариуцлага болон сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.

2.2.Зөвлөх мэргэшлийн зэргийг доор дурдсан шалгуур хангасан улсын байцаагчид олгоно. Үүнд:

2.2.1.энэ журмын 2.1 дэх хэсэгт заасан мэргэшлийн зэрэг хүчинтэй байх;

2.2.2.нийгмийн даатгалын байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан байх;

2.2.3.төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр сүүлийн 1 жилийн хугацаанд “Маш сайн”, “Хэвийн” үнэлгээтэй дүгнэгдсэн байх;

2.2.4.сүүлийн 1 жил ёс зүйн хариуцлага болон сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.

2.3.Итгэмжит зөвлөх мэргэшлийн зэргийг доор дурдсан шалгуур хангасан улсын байцаагчид олгоно. Үүнд:

2.3.1.энэ журмын 2.2 дахь хэсэгт заасан мэргэшлийн зэрэг хүчинтэй байх;

2.3.2.нийгмийн даатгалын байгууллагад 15-аас доошгүй жил ажилласан байх;

2.3.3.төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг сүүлийн 1 жилийн хугацаанд “Маш сайн”, “Хэвийн” үнэлгээтэй дүгнэгдсэн байх;

2.3.4.сүүлийн 1 жил ёс зүйн хариуцлага болон сахилгын шийтгэл хүлээгээгүй байх.

2.4.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, нийгмийн даатгалын улсын ерөнхий байцаагчид итгэмжит зөвлөхийн мэргэшлийн зэрэг олгоно.

### **Гурав.Мэргэшлийн зэрэг тогтоох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

3.1.Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газар нь улсын байцаагчид мэргэшлийн зэрэг тогтоолгох саналыг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахимаар ирүүлэх бөгөөд дараах баримт бичгийг цахимаар бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:

3.1.1.энэ журмын 2.1-2.3 дахь хэсэгт заасан шалгуур хангасныг нотлох баримт бичиг;

3.1.2.энэ журмын 3.1.1-д заасан нотлох баримт бичгийг үндэслэн хамт олны хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэр.

3.2.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь мэргэшлийн зэрэг тогтоолгох байцаагчийн баримт бичгийг шалгаж нэгтгэн, судалгааг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.

3.3.Мэргэшлийн зэргийг тогтоох асуудлыг хөдөлмөр, нийгмийн

хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор шийдвэрлэнэ.

3.4.Мэргэшлийн зэргийг дараах тохиолдолд түдгэлзүүлнэ. Үүнд:

3.4.1.улсын байцаагчийн эрхийг баталгаажуулах шалгалтад тэнцээгүй тохиолдолд дараагийн шалгалтад тэнцэх хүртэл хугацаанд;

3.4.2.хүүхэд асрах чөлөөтэй байгаа хугацаанд;

3.4.3.гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр “Хангалтгүй” дүгнэгдсэн бол дараагийн “Маш сайн, Хэвийн” үнэлгээ авах хүртэл хугацаанд;

3.4.4.ёс зүйн хариуцлага болон сахилгын шийтгэл хүлээлгэсэн өдрөөс хойш 1 жилийн хугацаанд.

3.5.Мэргэшлийн зэргийг түдгэлзүүлсэн хугацаанд мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгохгүй.

3.6.Нийгмийн даатгалын байгууллага хооронд шилжин эсхүл сэлгэн ажиллах хугацаанд тухайн албан хаагчийн мэргэшлийн зэрэг хэвээр хадгалагдана.

3.7.Мэргэшлийн зэргийг дараах тохиолдолд хүчингүй болгоно. Үүнд:

3.7.1.улсын байцаагчийн эрхийг баталгаажуулах шалгалтад 2 удаа тэнцээгүй тохиолдолд дараагийн шалгалтад тэнцэх хүртэл хугацаанд;

3.7.2.төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, чөлөөлөгдсөн, өөр байгууллагад шилжсэн, халагдсан.

3.8.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага мэргэшлийн зэргийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай саналыг тухай бүр хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

3.9.Энэ журмын 3.4.2-3.4.4-т заасан тохиолдолд журмын 1.5, 3.8 дахь хэсэгт заасныг харгалзахгүй тухайн хугацаанд нь мэргэшлийн зэргийг түдгэлзүүлж, сэргээнэ.

### **Дөрөв.Зэргийн нэмэгдэл олгох**

4.1.Энэ журмын 2.1-2.3 дахь хэсэгт заасан шалгуур хангасан улсын байцаагчид шат дараалан мэргэшлийн зэргийг олгоно. Мэргэшлийн зэргийг шат дараалан олгох доод хугацаа 1 жил байна.

4.2.Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нийгмийн даатгалын байгууллагад улсын байцаагчийн эрхтэйгээр төрийн жинхэнэ албан хаагчаар ажиллаж байгаа хугацаанд олгоно.

4.3.Энэ журмын 3.9 дэх хэсэгт заасны дагуу мэргэшлийн зэрэг сэргэсэн албан хаагчийн мэргэшлийн зэргийн нэмэгдлийг сэргэсэн хугацаанаас нь эхлэн шууд олгоно.

4.4.Төрийн өөр байгууллагад шилжин ажилласан төрийн жинхэнэ

албан хаагч нийгмийн даатгалын байгууллагад дахин томилогдож, улсын байцаагчийн эрхээ сэргээсэн тохиолдолд өмнө эзэмшиж байсан мэргэшлийн зэргийг нь сэргээн олгоно.

4.5.Нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга, нийгмийн даатгалын улсын ерөнхий байцаагчид итгэмжит зөвлөхийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгоно.

#### **Тав.Бусад зүйл**

5.1.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 7596 дугаарт бүртгээ

## **БОЛОВСРОЛЫН САЙДЫН ТУШААЛ**

2026 оны 5 дугаар  
сарын 07-ны өдөр

Дугаар А/42

Улаанбаатар  
хот

### **ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Сурах бичгийн эх зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Х.Тамир)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаалын хавсралтаар баталсан журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг танилцуулахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т даалгасугай.

4.Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн “Журам батлах тухай” А/87 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

*Боловсролын сайдын 2026 оны 5 дугаар сарын 07-ны  
өдрийн А/42 дугаар тушаалын хавсралт*

**СУРАХ БИЧГИЙН ЭХИЙГ ЗОХИОХ, САНАЛ АВАХ, ДҮГНЭЛТ  
ГАРГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг зүйл**

1.1.Ерөнхий боловсролын сурах бичиг (цаашид “сурах бичиг” гэх)-ийн эх зохиох, санал авах, дүгнэлт гаргуулахтай холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Сурах бичгийн эх зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагаа нь ил тод, нээлттэй, талуудын оролцоог тэгш хангасан, шинжлэх ухааны үндэслэлтэй, хүүхэд төвт сургалтын үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн байх бөгөөд төр, хувийн хэвшлийн хамтын оролцоо, хариуцлагын зарчимд суурилсан байна.

1.3.Сурах бичиг нь судлагдахууны онцлогоос хамааран суралцагчийн ном, багшийн ном, дасгал ажлын дэвтэр бүхий багц байна.

1.4.Сурах бичиг нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 11.5-д заасан хэлбэртэй байна.

1.5.Сурах бичгийн эх нь сургалтын хөтөлбөр, суралцагчийн нас, хөгжлийн онцлогт нийцсэн, сурах бичгийн стандарт, шаардлагыг хангасан, зохиогчийн эрхийн зөрчилгүй, эрх бүхий байгууллагын дүгнэлттэй, хэвлэн олшруулахад бэлэн болсон бүтээгдэхүүн байна.

**Хоёр.Сурах бичгийн эх зохиох**

2.1.Сурах бичгийн эх зохиох үйл ажиллагааг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага доор дурдсаны дагуу зохион байгуулна:

2.1.1.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 11.1-д заасан жагсаалтад багтсан сурах бичгийн эх зохиох хэвлэлийн газрыг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулах;

2.1.2.сурах бичгийн эхэд санал авах үйл ажиллагааг зохион байгуулахад эх зохиосон хэвлэлийн газарт дэмжлэг үзүүлэх;

2.1.3.энэ журмын 2.1.1-д заасны дагуу зохиосон сурах бичгийн эхэд боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагаар дүгнэлт гаргуулах;

2.1.4.бага ангийн суралцагчийн номыг үндэстний цөөнхийн эх хэлээр хөрвүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

2.1.5.судлагдахууны онцлог, суралцагчийн ялгаатай хэрэгцээнд

нийцүүлэн зарим сурах бичгийг аудио хэлбэр, брайл бичигт хөрвүүлэх, тохируулга хийх үйл ажиллагаа зохион байгуулах.

### **Гурав.Сурах бичгийн эхэд санал авах, дүгнэлт гаргуулах**

3.1.Сурах бичгийн эхийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудсанд нээлттэй байршуулна.

3.2.Хэвлэлийн газар нь сурах бичгийн эхэд Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 11.3-т заасан төлөөллөөс санал авсан байна.

3.3.Энэ журмын 3.2-т заасан санал авах үйл ажиллагааг сурах бичгийн эхэд дүгнэлт гаргуулахаас өмнө зохион байгуулна.

3.4.Сурах бичгийн эхэд Хэлний бодлогын үндэсний зөвлөл, хүний эрх болон жендэрийн асуудал хариуцсан холбогдох байгууллага, сурагчийн холбооноос санал авах үйл ажиллагааг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

3.5.Сурах бичгийн эхэд дүгнэлт гаргах үйл ажиллагааг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага хариуцна.

3.6.Сурах бичгийн эхэд дүгнэлт гаргах шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага батална.

3.7.Энэ журмын 3.5-д заасан байгууллага нь мэргэжлийн, сурах бичгийн эх зохиох үйл ажиллагаанд оролцоогүй, ашиг сонирхлын зөрчилгүй шинжээчийг томилно.

3.8.Шинжээч нь батлагдсан шалгуурын дагуу сурах бичгийн эхэд хараат бус, мэргэжлийн дүгнэлт, сайжруулах зөвлөмж гаргана.

3.9.Шинжээч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу дүгнэлт гаргах үйл ажиллагаа эхлэхийн өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргана.

3.10.Хэвлэлийн газар нь энэ журмын 3.8-д заасан дүгнэлт, зөвлөмжид үндэслэн сурах бичгийн эхэд шаардлагатай засвар, сайжруулалт хийнэ.

3.11.Шинжээчийн ажлын хөлсийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэнэ.

### **Дөрөв.Бусад**

4.1.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь сурах бичгийн хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, түгээх ажлын гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулах ажлыг зохион байгуулна.

4.2.Дасгал ажлын дэвтрийг суралцагч худалдан авч хэрэглэнэ.

4.3.Сурах бичгийг сургалтад хэрэглэх явцад сайжруулах үйл

ажиллагааг тухайн сурах бичиг зохиосон хэвлэлийн газар хариуцна.

4.4. Сурах бичгийн эхэд зохиогчийн эрхийн зөрчил гарсан тохиолдолд тухайн асуудлыг хэвлэлийн газар хариуцна.

4.5. Сурах бичгийн эх зохиох үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн оролцоог тэгш хангаж, аль нэг талд давуу эрх үүсгэхгүй.

4.6. Сурах бичгийн агуулга, хэл найруулгын алдаа гарах тохиолдолд хэвлэлийн газар хариуцлага хүлээнэ.

## СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 4 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар А/87

Улаанбаатар  
хот

### ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалт, 8.4. дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.4, 66.5 дахь хэсэг Хэмжил зүйн тухай хуулийн дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 1/1597 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/365 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах журам”-ын 4.1 дэх заалтын “... үр дүнг хүлээн зөвшөөрч болно.” гэснийг “.... үр дүнг хүлээн зөвшөөрнө.” гэж өөрчилсүгэй.

2. Журамд оруулсан өөрчлөлтийг ажлын 10 өдрийн дотор Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хэмжил зүйн бодлогын газар (Д.Бэхбат)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү журмын өөрчлөлтийг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Санчирдорж)-т даалгасугай.

ДАРГА

С.БАТБААТАР



## **МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ**

2026 оны 5 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар А/124

Улаанбаатар  
хот

### **ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ**

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд эрх олгосон хуулийн үйлчлэх хугацаа дуусгавар болсон тул Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/100 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Банкнаас цахим хэлбэрээр зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах тухай түр журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Эрсдэлийн удирдлага, дотоод аудитын газар (Д.Баянзул)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

С.НАРАНЦОГТ

## **САНГИЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2026 оны 4 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар А/94, А/162, А/56

Улаанбаатар  
хот

### **ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Статистикийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны “Захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэх зарим арга хэмжээний тухай” 206 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайд, Эрүүл мэндийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын “Эрүүл мэндийн үндэсний тооцооны ангилал батлах тухай” 2003 оны 226, 193, 157 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Хүчингүй болсон тушаалыг захиргааны хэм, хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлээс хасуулах арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Эрдэнэбаяр)-д даалгасугай.

САНГИЙН САЙД  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА

З.МЭНДСАЙХАН  
Э.БАТШУГАР  
Б.БАТДАВАА